МЭДЭЭ · 2020 оны 4-р сарын 1

ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛАХГҮЙГЭЭР ТЭНСЭГДСЭН ХҮНЭЭС МАНСУУРУУЛАХ БОДИС ХЭРЭГЛЭСЭН БАЙЖ БОЛЗОШГҮЙ СЭЖИГ ИЛЭРЧЭЭ



Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах" гэмт хэрэгт ял шийтгүүлэн Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хяналтанд байгаа иргэд шүүхээс даалгасан үүрэг, хориглосон хязгаарлалтыг хэрхэн биелүүлж байгаа байдлыг шалгажээ.



Тестын хариу
Илрээгүй
Илрээгүй
Илрээгүй
Илрээгүй
Илэрсэн, 1971 оны Сэтгэцэд нөлөөт бодисын тухай конвенцын II жагсаалтад орсон дельта-9 тетрагидроканнабинол буюу өвс хэрэглэсэн байж болзошгүй.
Илрээгүй
Илрээгүй
Илрээгүй
Илрээгүй
Илрээгүй
Илрээгүй

Шалгалтыг дүүргийн Цагдаагийн газар болон Эрүүгийн цагдаагийн газрын Хар тамхитай тэмцэх газартай хамтран зохион байгуулан бөгөөд Дархан-Уул аймгийн шүүхээс хорих ял оногдуулахгүйгээр 1 жилийн хугацаагаар тэнсэгдсэн М гэгчээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн байж болзошгүй сэжиг илэрч, харьяа Цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн байна.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3087